

Улсын бүртгэлийн дугаар  
Аравтын бүрэн  
Ангиллын код

Нууцын зэрэглэл:Б  
Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар  
ШуСс-2019/62

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

**БНМАУ-ЫН НИЙГЭМ ЭДИЙН  
ЗАСГИЙН ОЛОЛТ: ТУРШЛАГА, СУРГАМЖ  
(1954 ОНООС 1980-ААД ОНЫ СҮҮЛЧ)**

**Суурь судалгааны төсөл  
2019-2022**

**Төслийн гүйцэтгэгч:**

**Түүх, угсаатны зүйн хүрээлэн**

**Төслийн удирдагч:**

**Б.Пунсалдулам-доктор (Sc.D),  
профессор Түүх, угсаатны зүйн  
хүрээлэнгийн Ойрх үеийн судалгааны  
салбарын ЭШТА**

**Санхүүжүүлэгч байгууллага:**

**Шинжлэх ухаан технологийн сан**

**Захиалагч байгууллага:**

**Боловсрол, шинжлэх ухааны яам**

**Тайлан өмчлөгч:**

**Түүх, угсаатны зүйн хүрээлэн  
Монгол улс, 13330 Улаанбаатар хот,  
БЗД, 13-р хороо, Энхтайваны өргөн  
чөлөө. Утас:11-458305,  
Цахим шуудан:history@mas.ac.mn**

**УЛААНБААТАР**

**2023**

## Реферат

Судалгааны багийн хамт олон бид өнгөрсөн түүхийг, ялангуяа өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн явц, нүүр царайг жишиж харах боломжтой өнгөрсөн зууны түүхийг судлан үнэлгээ дүгнэлт өгөх нь түүхийн судалгааны тулгамдсан асуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ улс орны хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодруулах, удирдан чиглүүлэхэд зайлшгүй шаардлагатай уялдуулан “социализмын материал техникийн баазыг барьж байгуулах” хэмээн тухайн үеийн ном бүтээлүүдэд нэрлэгддэг үеийг сонгон авч, нийгэм эдийн засгийн хөгжлийн түүхийг түүхийн судалгааны хүрсэн түвшинд нэгтгэн, шинээр үнэлэн дүгнэлт өгөх зорилгоор ажилласан болно.

Ийнхүү зорихдоо түүх шинэчлэлийн өмнөх түүх бичлэгт ноёрхож ирсэн түүхийн судалгаанд хар, цагаан толбо үүсгэх, эзэнгүйдүүлэх, гажуудуулах догматик арга зүйг халж, аливаа түүхэн үйл явцыг тухайн үеийн нөхцөл, оюун сэтгэлгээний түвшинд асуудлыг “түүхэн историзм-ын үүднээс шинжлэн, архивын болон статистикийн баримт, аман түүхийн судалгаанд түшиглэн арга зүйн шинэ хандлагаар бичив.

Суурь судалгааны төслийн хүрээнд, хамтын бүтээлээс гадна, түүхийн судалгааг цаашид гүнзгийрүүлэн судлах, мөн сургалтад хэрэглэх зорилгоор “Монгол улсын газар тариалан (1911-2020 он)” баримтын эмхэтгэлийг хэвлүүллээ.

Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам заасны дагуу судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх хүрээнд “Соёлын довтолгоо” хялбаршуулсан товхимлыг нийтэд зориулан хэвлэн гаргав. Мөн суурь судалгааны төслийн хүрээнд хэвлэгдсэн бүтээлүүдийг олон нийтэд сурталчлав.

**Түлхүүр үг:** нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, төлөвлөгөө, түүх, улс төр, бүтээн байгуулалт, социалист, социализм гэх мэт.

## ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

1. Намжилчойжилын Алтантөгс, МУИС-ын багш, доктор (Ph.D), дэд профессор (IV бүлгийн §4.5)
2. Сэржлхүмбийн Амарбаяр, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D), (Ж.Болдбаатарын хамт VII бүлгийн §7.3,)
3. Цэдэндамбын Батбаяр, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, академич (II бүлгийн §2.1, §2.2, §2.3)
4. Жигжидийн Болдбаатар, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, академич (I бүлгийн §1.1, §1.2, §1.3., IV бүлгийн §4.2, VII бүлгийн §7.2, §7.3)
5. Чагдарсүмбэрэлийн Батдорж, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D), (VIII бүлгийн §8.4)
6. Борын Пунсалдулам, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Sc.D), профессор (VI бүлгийн §6.1, §6.2, §6.3, §6.4, IV бүлгийн §4.1, §4.3, VII бүлгийн §7.1, VIII бүлгийн §8.2)
7. Галиндэвийн Мягмарсамбуу, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D), профессор (III бүлгийн §3.1, §3.2, §3.3)
8. Ганбатын Цэрэнсугар, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, магистр (VIII бүлгийн §8.3)
9. Цэвэгдоржийн Энхжаргал, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, магистр (VIII бүлгийн §8.1)
10. Дандарваанчигийн Эрдэнэбат, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D), (V бүлгийн §5.1, §5.2, §5.3, IV бүлгийн §4.4)

## ГАРЧИГ

Реферат, түлхүүр үг.....	2
Гүйцэтгэгчдийн нэрийн жагсаалт.....	3
Товчилсон үгийн жагсаалт.....	5
Тайлангийн удиртгал.....	6-7
Тайлангийн үндсэн хэсэг.....	8-20
Дүгнэлт.....	21
Номзүй.....	22-27
Хавсралт №1. Хэвлүүлсэн бүтээл.....	28-29
Хавсралт №2. Эрдэм шинжилгээний илтгэл.....	30
Хавсралт №3. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	31-74

## Товчилсон үгийн жагсаалт

БНМАУ-Бүгд Найрамдах Монгол Ард Улс  
МАХН-Монгол Ардын Хувьсгалт Нам  
МУБИС-Монгол Улсын Боловсролын Их Сургууль  
МУИС-Монгол Улсын Их Сургууль  
МҮОНРТ-Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз  
СнЗ-Сайд нарын Зөвлөл  
УААА-Улс Ардын Аж Ахуй  
ХАА-Хөдөө Аж Ахуй  
ХААН-Хөдөө Аж Ахуйн Нэгдэл  
ШУА-Шинжлэх Ухааны Академи  
ШУС-Шинжлэх Ухааны Сургууль

## УДИРТГАЛ

XX зууны монголчуудын түүх бүхэлдээ зогсолтгүй урагшилсан түүх, урам зориг, сурах хүсэл тэмүүлэл, ухаарал, сургамж, бүтээн байгуулсан он жилүүдийн түүх юм. Өнгөрсөн зууны монголчуудын бүтээсэн ололт, амжилтыг гурван зүйлд багцалж болно. Үүнд:

1. XX зуунд монголчууд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хувьсгал хийж, Монгол төрийн тусгаар тогтнолыг тунхаглан баталгаажуулж, дэлхийн улс түмэнд хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын нэр хүнд бүхий байгууллагын гишүүнээр элсэн ажиллаж улмаар гадаад харилцаагаа өргөжүүлэн тэлж чадсан бүрэн эрх улс болон хөгжиж байна.
2. Капитализмын өмнөх үеийн нийгмийн харилцаанд байсан Монгол орон XX зуунд бүх нийтээрээ бичиг үсэгт суралцаж, улмаар орчин үеийн боловсролын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэн төлөвшүүлж, үндэсний сэхээтэн, мэргэжилтэй ажилчныг сурган бэлтгэх болжээ. Түүнчлэн тус улсад шинжлэх ухааны олон салбар өргөжиж хөгжиж, эрдмийн зэрэг цолтой үндэсний судлаачид төрөн гарч, тэдний судалгаа, бүтээлүүд хэвлэгдэн, үйлдвэрлэлд нэвтрэх болжээ.
3. XX зууны хоёр дугаар хагасаас монголчууд их бүтээн байгуулалтыг өрнүүлж, нүүдлийн мал аж ахуйн орноос Хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн орон болон хөгжиж чадсан байна.

Дээрх ололт амжилтыг дардан замаар амар хялбар олж аваагүйг бид бүхэн сайн мэднэ. Бидэнд мэдэхгүй чадахгүй, хүчрэхгүй, хүчгүйдсэн цаг хугацаа байсныг үгүйсгэхгүй. Гэвч дээрх ололт амжилтыг хэн ч үгүйсгэх, харлуулах, мушгин гуйвуулах боломжгүй юм. Учир энэ бүхэн бодиттой үйл явц байсан бөгөөд үүний үр дүнд өнөөгийн Монгол улсын бүрэн эрхт байдал, хүн ардын мэдлэг боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухааны мэдлэг тасралтгүй хөгжин дэвшиж дээшилсээр байна.

XX зууны бүтээн байгуулалт амжилттай өрнөсөн гол хүчин зүйл, хөдөлгөх хүч нь Монгол төрийн тусгаар тогтнол, эх орны нэр хүнд, хүч чадалд итгэсэн монголчуудын хүсэл тэмүүлэл, итгэл мөрөөдөл бүтээлч хөдөлмөр байсан юм. Энэ зуунд, ялангуяа бидний сонгон авсан 1954-1980-аад оны БНМАУ-д хөдөлмөрийн хүнийг хүндэтгэн алдаршуулж, тэдний нийгмийн хамгааллын

тогтолцоог төлөвшүүлэн ажиллах бололцоо нөхцөл, боловсрол, эрүүл мэндэд анхаарал тавьж олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байв.

Гэтэл сүүлийн үед, түүхийг шинээр харах, алдаа гажуудлыг залруулах нэрийн доор БНМАУ-ын нийгэм-эдийн засагт олсон ололтыг бүхэлд нь улс төрийн болон өмчийн харилцааны үүднээс голлон харж буруутган “социализмын 70 жил” хэмээх нэр хочийг бүх үед зүүж, боловсрол, шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт олсон ололт амжилтыг үл тоомсорлон үгүйсгэж, зөвхөн алдаа, дутагдлуудыг тоочих нь хирээс хэтэрч байна.

XX зууны бүтээн байгуулалтын он жилүүдэд монголчууд дэлхийд танигдаж, тусгаар улсаа батлан тунхаглаж, нүүдлийн мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болж, нийгэм соёл боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн чанарын цоо шинэ түвшинд хүрч чадсан юм. Үнэндээ өнөөгийн монголын эдийн засаг социализмын бүтээн байгуулалтын он жилүүдэд бүтээгдсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн бүхэл бүтэн цогцолборуудыг өмч хувьчлал нэрийн дор хэдхэн хүмүүс хувьдаа завшин өмчилж, тус улсын аж үйлдвэрлэл үндсэндээ бүрэн зогсож, улс орон худалдаа, арилжааны орон болон хувирч, бусад улсын бараа бүтээгдэхүүн, валют, хил гааль, зан аашаас ихэд хамаарах болжээ.

Бүтээн байгуулалтын жилүүдэд амьдарч, хөдөлмөрлөж явснаа дурсахаар “хөгшин хүмүүс дандаа залуу насандаа сайхан байсан” гэж ярьдаг юм, тэгдэг зүй тогтолтой, “1950, 1960, 1970-аад оныхон үхэж байж л нийгэм цэвэршинэ” гэх мэтээр аль болох бараан ойлголтыг нийгэмд цацан түгээж, хүүхэд залуусын толгойг эргүүлэх боллоо.

Иймд, өнгөрсөн түүхийг, ялангуяа өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн явц, нүүр царайг жишиж харах боломжтой өнгөрсөн зууны түүхийг судлан үнэлгээ дүгнэлт өгөх нь түүхийн судалгааны тулгамдсан асуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ улс орны хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодруулах, удирдан чиглүүлэхэд зайлшгүй шаардлагатай уялдуулан “социализмын материал техникийн баазыг барьж байгуулах” хэмээн тухайн үеийн ном бүтээлүүдэд нэрлэгддэг үеийг сонгон авч, нийгэм эдийн засгийн хөгжлийн түүхийг түүхийн судалгааны хүрсэн түвшинд нэгтгэн, шинээр үнэлэн дүгнэлт өгөх зорилгоор суурь судалгааны төслийн багийн гишүүд ажиллав.

**“БНМАУ-ЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОЛТ: ТУРШЛАГА, СУРГАМЖ  
(1954-1980-ААД ОНЫ СҮҮЛЧ) № ШУСС-2019/62 СУУРЬ СУДАЛГААНЫ  
ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН**

“БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийг дараах судлаачдын багийн хамт амжилттай хийж гүйцэтгэв. Үүнд: Суурь судалгааны төслийн удирдагчаар түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, гүйцэтгэгч, зохиогчоор академич Ж.Болдбаатар, академич Ц.Батбаяр, доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу, доктор (Ph.D), дэд профессор Н.Алтантөгс, доктор (Ph.D) Ч.Батдорж, Д.Эрдэнэбат, С.Амарбаяр, магистр Ц.Энхжаргал, Г.Цэрэнсугар нар оролцон ажиллаа. Судалгааны багийн чанарын үзүүлэлтийг тодруулбал: шинжлэх ухааны доктор-3, түүхийн ухааны доктор-5, магистр-2.

Судалгааны багийн хамт олон төслийн өмнөө тавьсан зорилтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага, түүнчлэн түүхийн шинжлэх ухааны судалгааны түвшинд нэгтгэн боловсруулж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагын хүрээнд, суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний төслийн үр дүнгийн даалгаврын календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэв. Түүнчлэн суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн дугаар ШуСс-2019/62 гэрээний 3.2.2 зүйлийн дагуу санхүүгийн мэдээ, тайланг цаг хугацаанд нь зохих шатны байгууллагад гаргаж, үүрэг хариуцлагаа биелүүлэн ажиллаа.

Мөн 2022 оны 11 дүгээр сарын 19-нд Шинжлэх ухааны технологийн сангаас төслийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ явуулсан ажлын хэсгээр “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцүүлж, 98 хувийн үнэлгээ авсан болно.

“БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийн календарчилсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 9 дүгээр сарын 21-нд ШУА-ийн нэгдсэн I байрны зохиогдсон “БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрх үеийн түүхийн салбар, Нийгэм, соёлын хүн судлалын салбар, Олон судлалын хүрээлэн, МУИС-ийн ШУС-ийн Түүхийн тэнхим, МУБИС-ийн түүхийн тэнхим,



Үндэсний музей, хувийн их дээд сургуулийн багш, магистр, докторантууд идэвхтэй оролцож, ХХ зууны хоёр дугаар хагасаас хойших монголын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын хөгжлийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлсэн санал, бодол, үзэл дүгнэлтийг хамтын бүтээлд тусгасан болно.

**Судалгааны ажлын арга зүй.** Түүх шинэчлэлийн өмнөх түүх бичлэгт ноёрхож ирсэн түүхийн судалгаанд хар, цагаан толбо үүсгэх, эзэнгүйдүүлэх, гажуудуулах догматик арга зүйг халж, аливаа түүхэн үйл явцыг тухайн үеийн нөхцөл, оюун сэтгэлгээний түвшинд асуудлыг “түүхэн историзм-ын үүднээс шинжлэн, архивын болон статистикийн баримт, аман түүхийн судалгаанд түшиглэн арга зүйн шинэ хандлагаар бичив.

**Суурь судалгааны ажлын зорилт.** Тухайн чиглэлээр явагдсан судалгааны үр дүнг нэгтгэн, шинэлэг арга зүйд тулгуурлан архивын баримт болон бусад хэрэглэгдэхүүнийг илрүүлэн ашиглаж, ХХ зууны сүүлийн хагасын Монголын түүхийг цогц байдлаар нэгтгэн дүгнэж, тухайн сэдвийн судалгааг шинэ төвшинд гаргасан, шинэ мэдлэг бүхий бүтээл туурвих зорилт тавьсан болно.

Үүний тулд дараах зорилтуудыг шийдвэрлэв.

а/ БНМАУ-ын бүтээн байгуулалт өрнөх болсон үндсэн нөхцөл суурь хэрхэн бүрдсэн, гадаад, дотоод хүчин зүйлийг тодруулах

б/ Бүтээн байгуулалтын бэлтгэл, өрнөл, явцыг тодруулахын тулд үе шатад хуваах

в/ 1954-1980-аад оны сүүлч үеийн Монголын төрийн байгуулалт, улс төрийн харилцаа, гадаад орчин нөхцөлийн түүхийг тодруулах

г/ “Социалист” бүтээн байгуулалтын дотоод, гадаад болон өөр хоорондын уялдаа холбоо, гол үр дүн юу болохыг тодруулж, үнэлгээ дүгнэлт өгөх

д/ Түүнчлэн бүтээн байгуулалтын үйл явцын мухардал, түүнээс гарах арга замыг эрэлхийлж байсныг гаргах

е/ Бүтээн байгуулалтын жилүүдэд төрөөс соёлын талаар баримталсан бодлого, түүний бүрэлдэхүүн хэсгийг тодруулж, үзэл суртал, улс төрийн үнэлгээ, дүгнэлтээс салган ойлгох, түүнийг бүтээн байгуулалтын үйл явцын салшгүй нэгэн хэсэг болохыг харуулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж, дараах бүтээлүүдийг хэвлэн гаргав.

**“БНМАУ-ЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОЛТ: ТУРШЛАГА, СУРГАМЖ (1954-1980-ААД ОНЫ СҮҮЛЧ) ШУСС-2019/62 ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

**I. Хамтын бүтээл:**

Засгийн Газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын 1.4.1. “суурь судалгааны төсөл” гэж хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг, мэдээллийг бий болгоход чиглэсэн байх зорилтын хүрээнд дараах шинэ мэдлэг агуулсан хамтын бүтээлийг туурвисан болно. Хамтын бүтээлийг хэвлүүлэхийн өмнө МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш доктор (Ph.D), дэд профессор Ч.Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор С.Энхжин нараар уншуулан хөндлөнгийн үнэлгээ шүүмж хийлгэн, нэмэн засварлаж, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санал, шүүмжийг тусгасан болно.

**“БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сургамж)** Зохиогчид академич Ж.Болдбаатар, академич Ц.Батбаяр, доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу, доктор(Ph.D), дэд профессор Н.Алтантөгс, доктор (Ph.D) Ч.Батдорж, Д.Эрдэнэбат, С.Амарбаяр, магистр Ц.Энхжаргал, Г.Цэрэнсугар. Редактор академич Г.Чулуунбаатар. Хэвлэлийн хуудас 37,7, Хэвлэлийн газар “Удам соёл”. Хэвлэсэн тоо 300 ш. УБ.,2022.

“БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад он)” хамтын бүтээл нь редакторын зурвас, удиртгал, найман бүлэг, 28 зүйл, төгсгөл, хүний нэрсийн хэлхээ, улс орон, хот, аймаг, газар усны нэрийн хэлхээ, ном зүйгээс бүтнэ.

Хамтын бүтээлийн “БНМАУ-ын улс төрийн тогтолцоо” нэгдүгээр бүлэгт (зохиогч академич Ж.Болдбаатар) ХХ зууны хоёр дугаар хагасаас хойших Монголын улс төрийн харилцааны өөрчлөлт, ялангуяа 1954-1960-аад оны дунд үе хүртэлх улс төрийн харилцааны зөрчил, үзэл сурталжуулах үйл явц, МАХН-ын удирдлагын зарчим, түүнд нөлөөлсөн гадны хүчин зүйл зэрэг тулгамдсан асуудлыг хөндөн судалж, тухайн үед захиран тушаах тогтолцоог эсэргүүцсэн аливаа илрэлийг хайр найргүй нухчин дарж, нийгмийн оюун санааны амьдралыг бүхэлд нь хянан цагдах үзэл суртлын хатуу хяналт тогтож байсныг баримт түшин гаргаж, 1960-аад оны дунд үеэр ганцаар захирах дэглэм тогтох болсны учир холбогдлын онол танин мэдэхүйн үндсийг нээн харуулав. Мөн БНМАУ-ын төрийн

тогтолцооны өөрчлөлт, хөгжил, эрх зүйн зохицуулалтын мөн чанарыг гарган дэлгэж, улс төрийн тогтолцооны цөм нь МАХН хэмээн үзэж, төрийн үүрэг ролийг хэрхэн бууруулж байсныг тодруулав.

“БНМАУ-ын гадаад орчин, гадаад харилцаа” хоёр дугаар бүлэгт (зохиогч академич Ц.Батбаяр) “Хүйтэн дайн”-ны үеийн олон улсын харилцаа, түүнд БНМАУ-ын эзлэх байр суурь, ЗХУ, БНХАУ-тай хоёр талын болон, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын харилцааг бүхэлд судлан үнэлэлт дүгнэлт өгчээ. 1960-1990 оны хооронд БНМАУ нь дэлхийн эсрэг тэсрэг хоёр блок Өрнө, Дорнодын хүйтэн дайнд социалист нөхөрлөлийн нэг гишүүн байсан төдийгүй, 1960-аад оноос эхэлсэн Зөвлөлт-Хятадын хүйтэн дайны шууд оролцогч болсон бөгөөд дээрх хоёр орны харилцаа бүх талаар хурцдаж, Даманскт хийлийн мөргөлдөөн гарснаар Монголын нутагт ЗХУ-ын цэрэг орж ирсэн тухай асуудлыг нягтлан судалж үнэлгээ, дүгнэлт өгчээ. Түүнчлэн социалист орнуудын хамтын нөхөрлөлийн хямрал, 1950-иад оны Унгар, 1960-аад оны Чехословак, 1970-аад оны Польшийн хямралын асуудлыг хөндөн судалгааны хүрээнд тодруулсан байна.

“Төрийн батлан хамгаалах бодлого, үр дүн” гуравдугаар бүлэгт (зохиогч доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу) БНМАУ-ын төрөөс баримталсан батлан хамгаалах бодлого, түүний хэрэгжилтийг цогц хүрээнд судлан үнэлгээ өгчээ. Улс орны батлан хамгаалах хүчийг зузаатгах гадаад, дотоод нөхцөл шалтгаан, Монголын ардын армийн бэхжилт, түүний монголын бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмрийг үнэлэн дүгнэсэн байна. Түүнчлэн Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтын ажиллагаа, цэргийн мэргэжилтнүүд, зөвлөлтийн цэргийн ангиудын байрлал, үүрэг зорилтын талаар судалгаа хийжээ.

“Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжил” дөрөвдүгээр бүлэгт (зохиогч доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, академич Ж.Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор Н.Алтантөгс, доктор (Ph.D) Д.Эрдэнэбат) УААА, соёлыг хөгжүүлэх гурван жилийн төлөвлөгөө, түүнийг явуулах болсон учир шалтгааныг гадаад, дотоод нөхцөл байдал болон тухайн үеийн БНМАУ-ын нийгэм, улс төрийн харилцааны дэвшүүлж буй зорилттой уялдуулан нягтлан шинжилж, ХХ зууны хоёр дугаар хагасаас хойших БНМАУ-ын бүтээн байгуулалтын хөгжлийн хоёр үед хуваан авч үзэв. Үүнд:

а/. 1954-1960 он буюу “Социалист” бүтээн байгуулалтын өмчийн харилцааны суурийг бэхжүүлж, тогтоох үед БНМАУ-ын УААА-д өмчийн олон хэвшил (улс, хоршоолол, хувийн болон амины) оршин тогтнож байсан бөгөөд

түүнийг нийгмийн өмчид шилжүүлснээр “социалист” бүтэн байгуулалтын үйл явц хурдацтай, нэгдсэн, төвлөрсөн хэлбэрээр явагдах үндсэн нөхцөл бүрджээ.

б/. 1961-1980-аад оны сүүлч буюу бүтээн байгуулалтын өрнөл үе хэмээн үечилж, УААА, соёлыг хөгжүүлэх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийн үе хэмээн нэрлэх зүйтэй болох талаар өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг өгчээ.

Тус улсад социалист үйлдвэрлэлийн харилцааг тогтоох хүрээнд хийгдсэн ардын аж ахуйтныг хоршоолох хөдөлгөөний явц, амжилт, саад бэрхшээлийг гарган тавьж, захиргаадан нэгтгэсэн болохыг баримтад тулгуурлан гаргаж, түүний цаашдын үйл явцад дүн шинжилгээ хийж, социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсан нь мөн чанартаа өмчийн олон хэлбэр, хувийн өмчийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүргийг бүрмөсөн үгүйсгэж, хувийн сонирхол, идэвхийг бууруулан бэлэнчлэх сэтгэлгээг газар авах нөхцөлийг бүрдүүлсэн хэмээх дүгнэлтийг өгсөн байна. Мөн өмнөх түүх бичлэгт нэгдэлжих хөдөлгөөнийг эсэргүүцэгчдийг жижиг хөрөнгөтний бэртэгчин хэмээн бичиж, дүгнэж ирснийг шүүмжлэн, тухайн асуудлыг хүний өмчлөх эрх, өв хөрөнгө, хувийн ардын аж ахуйтны хөрөнгө чинээ, язгуур угсаа, боловсрол зэрэг олон талаас нь харсан үнэлгээ дүгнэлт өгөх хэрэгцээ шаардлага байгааг гарган тавьжээ.

Бүтээн байгуулалтын жилүүдэд тус улсад газар тариалангийн үйлдвэрлэл өргөжин тэлж, хөдөө аж ахуйн бие даасан салбар болон хөгжсөн түүхийг төрийн бодлого, шийдвэр, хэрэгжилтийн хүрээнд статистик тоо баримттай гарган тавьжээ. Аж үйлдвэрийн салбарын өсөлт, бэхжилт УААА, соёлыг хөгжүүлэх III-VIII таван жилийн төлөвлөгөөт зорилтын үед хийгдэж, олон арван үйлдвэр аж ахуйн газрууд шинээр байгуулагдан, үндэсний дээд, тусгай, мэргэжлийн ажиллах хүчин бүрэлдэн төлөвшсөнийг гарган харуулав.

БНМАУ-ын худалдааны салбарын хөгжил, тогтолцоо, улсын бэлтгэл, экспорт, үнэ ашиг, татвар зэрэг асуудлыг нэгтгэн судалж, бүтээн байгуулалтын жилүүдэд материаллаг үйлдвэрлэлийн салбарт бүтээгдсэн нөөц баялгийг Засгийн газрын мэдэлд авах улмаар нийгмийн дахин хуваарилалтад оруулах үндсэн арга зам нь худалдаа байсан бөгөөд худалдааны бүх төрлийн үнийг улсаас тогтоож, нийгэм-эдийн засгийг макро болон микро түвшинд удирдаж ирсэн монопольт худалдаа хэмээх дүгнэлтийг өгсөн байна.

“БНМАУ-ын дэд бүтцийн хөгжил” тавдугаар бүлэгт (зохиогч доктор (Ph.D) Д.Эрдэнэбат) Монгол улсын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөт жилүүдэд орчин үеийн тээврийн систем бүрэлдэн тогтсон нь улс орны эдийн

засгийн хөгжилд ихээхэн том түлхэц үзүүлжээ. Ялангуяа төмөр замын тээвэр нь дотоодын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд голлох үүрэг гүйцэтгэснээс гадна, Ази-Европыг холбосон олон улсын тээврийн уялдаа холбоог бий болгосон нь ХХ зууны Монгол улсын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулжээ. Монгол улсын тээврийн систем нь ердийн хөсөг, авто тээвэр, төмөр зам, агаар, усан замын болон ердийн хөсгийн тээврийн төрлүүдээс бүрдэж, төлөвлөгөөт жилүүдэд нэлээдгүй бэхжиж, нэгдсэн системийг улам батжуулсан байна. УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөт жилүүдэд Монгол улсын бүх төрлийн тээврийн материал-техникийн бааз бэхжиж, боловсон хүчний хувьд хангагдан, ачаа эргэлт нэмэгдэн, дэд бүтцийн салбарт ихээхэн ахиц гарсан байна.

УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөт жилүүдэд Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам нь төлөвлөлт, гүйцэтгэлийг системтэйгээр явуулж, барилгын материалын үйлдвэрүүдэд ажиллах үндэсний мэргэжилтэй боловсон хүчний бүрдэлтэй болж, барилгын материалын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх хүчин чадлыг ихэсгэснээр (тоосго, цемент) дотоодын нөөц бололцоог дайчлан, эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр бие даасан дэд бүтцийн томоохон салбар болох суурийг бүтээн байгуулалтын жилүүдэд баттай тавьсан юм. Эдгээр жилүүдэд барилгын байгууллагын барилга, байгууламжийн ажил эрчимжиж, улс ардын аж ахуйн бие даасан салбар болсон нь материаллаг үйлдвэрлэлийн салбарт гарсан томоохон дэвшил байлаа.

УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөт жилүүдэд материаллаг баялгийг үйлдвэрлэгч салбаруудын уялдаа холбоог сайжруулахад Харилцаа холбооны салбар нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн төдийгүй холбооны нэгдсэн сүлжээтэй болсон нь бүтээн байгуулалтын томоохон ололтын нэг байв.

“Боловсрол, шинжлэх ухааны хөгжил, амжилт” зургаадугаар бүлэгт (доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам) ХХ зууны Монголын боловсролын хөгжлийг улс төр, нийгмийн харилцааны чиг баримжаагаар үечлэн авч үздэг байсан өмнөх түүх бичлэгийн аргаас татгалзаж, тус улсад орчин цагийн боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн суурь тавигдаж, систем тогтолцооны хувьд бүрэлдэн хөгжсөн түүхэн хөгжлийг хоёр үед хуваан (ХХ зууны эхнээс 60-аад он хүртэл, 60-аад оноос хойших) гол үр дүнг үндэсний боловсон хүчний хөгжлийн түвшингээр тодорхойлон авч үзэх санал дэвшүүлэн, бүтээн байгуулалтын жилүүдэд Монголын боловсрол, шинжлэх ухааны үсрэнгүй хөгжсөн учир шалтгаан, үндэс суурийг гарган үзүүлжээ. Мөн Монголын орчин үеийн боловсролын тогтолцоо ХХ зууны эхнээс бүрэлдэн хөгжиж ирсэн боловч,

тогтолцооны хувьд бүтээн байгуулалтын жилүүдэд төлөвшсөн болохыг гарган, үнэлгээ дүгнэлт өглөө.

“Орчин цагийн соёл, утга зохиол, урлагийн хөгжил” долоо дугаар бүлэгт (зохиогч академич Ж.Болдбаатар, доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, доктор (Ph.D) С.Амарбаяр)

XX зуунд Монголын төрөөс соёлын талаар баримталсан бодлого, түүний уялдаа залгамж холбоог шинээр харж, үнэлгээ дүгнэлт өгөв. Ялангуяа бүтээн байгуулалтын жилүүдэд төрөөс баримталсан соёлын бодлогыг тухайн үеийн үзэл суртал, анги, намын ухуулга, шашингүйн үзлээс ялган салгаж ойлгох шаардлага байгааг дэлгэн харуулав. Түүнчлэн бүтээн байгуулалтын үйл явц, соёлын бодлого нь харилцан бие биеэ дэмжин хэрэгжиж ирсэн нь амжилт, ололтын гол үндэс байжээ хэмээх дүгнэлтийг өгөв. Бүтээн байгуулалтын жилүүдийн соёлын бодлого дөрвөн том хэсгээс бүрдсэн томоохон хөтөлбөр байсныг тодруулан гаргав. Бүтээн байгуулалтын үйл явц өрнөн хөгжих тусам улс орны нийгэм-оюуны амьдралд эрс өөрчлөлт гарч буйг тайз, дэлгэц, урлаг, утга зохиолын хөгжилд гарсан ололт амжилтын хамт гарган үзүүлэв.

“Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, биеийн тамир спорт” наймдугаар бүлэгт (зохиогч доктор (Sc.D), профессор Б.Пунсалдулам, доктор (Ph.D) Ч.Батдорж, магистр Ц.Энхжаргал, Г.Цэрэнсугар) бүтээн байгуулалтын он жилүүдэд БНМАУ-д нийгмийн хамгааллын систем тогтолцооны хувьд төлөвшин хөгжжээ. Нийгмийн хамгаалал хөгжлийн шинэ шатанд орж, хууль эрх зүйн тогтолцоо бүрэлдэн нийгмийн үйлчилгээний хүрээ нэмэгдэх болсныг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийн чухал ололтын нэг мөн болохыг харуулжээ. Улс орон даяар өрнөсөн бүтээн байгуулалт, соёлын бодлого, нийгмийн хамгааллын бодлогын зөв суурь чиглэл нь хүн амын өсөлт, нийгмийн бүтэц хувьсалд эерэг нөлөө үзүүлсэн болохыг баримт түшин харуулав.

## II. Баримтын эмхэтгэл:

**“Монгол улсын газар тариалан (1911-2020 он)”** баримтын эмхэтгэл. Эрхэлсэн Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. В5. х.х.29., Хэвлэлийн газар “Удам соёл” ХХК. Хэвлэсэн тоо 200ш. УБ.,2021.

XX зууны БНМАУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүхэнд олсон том ололт нь мал аж ахуйн орноос хөдөө аж ахуйн орон болон хувирсан явдал юм. Өгүүлэн буй үеийн газар тариалангийн хөгжлийн түүхийг судлан үзэхэд, газар тариаланг улс орны эдийн засаг, нийгэм, соёлыг хөгжүүлэх нэгдсэн бодлогын

салшгүй хэсэг болгон, төрийн бодлогоор дэмжин, шинжлэх ухаан, техникийн ололтод тулгуурлан, хөдөө аж ахуйн бие даасан салбарын хэмжээнд тогтвортой, эрчимтэй хөгжүүлжээ. Тус улсад газар тариаланг хөгжүүлж, ХАА-н бие даасан салбар болгон хөгжүүлэх боломж, нөхцөл, бүтээн байгуулалтын он жилүүдэд бүрэлдэн бий болсныг гарган үзүүлэх архивын холбогдох баримтуудыг эмхлэн нэгтгэн гаргах нь эрдэм шинжилгээ, судалгааны чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь тус улсад мал аж ахуй, хөнгөн болон хүнсний аж үйлдвэр, түлш эрчим хүч, тээвэр холбоо, нийгэм-соёл зэрэг УААА-н бусад салбарын хөгжилд чухал байр суурийг эзэлдэг.

Иймд, эмхэтгэлд газар тариалангийн түүхийг судлан боловсруулахад чухал хэрэглэгдэхүүн болох баримт материалуудыг 4 бүлэгт хуваан нийт 126 ширхэг архивын баримтыг оруулав. Тус эмхэтгэлд сэргэн мандсан Монгол улсын Засгийн Газрын 1913 оны “Тариалангийн газар түрээслэх дүрэм (16 зүйл) болон 1916 оны “Улсын хөрөнгийг захирах газрын дүрэм (57 зүйлийн 25 нь газар тариаланд зориулагдсан), 1918 онд батлагдсан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хуль зүйлийн бичиг” (65 дэвтэр, 12 дэвтэр “Сангийн амуу”) зэрэг гол хууль болон холбогдох хэсгийг бусад баримтын хамт оруулав.

Мөн Ардын Засгийн газар, БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол, шийдвэрүүд, газар тариалангийн талаар гарсан дүрэм, журам, хууль, тогтоомж, баримт бичгийг сонголт хийн орууллаа. Ингэхдээ газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлого, шийдвэр, авсан арга хэмжээ, атрын аянуудын түүхийг харуулах баримт, материалуудыг түлхүү түүвэрлэн оруулсан болно.

### III. Аман түүх, дурсамж

1. **“Чин сэтгэлийн үг”** дурсамж. Эрхэлсэн Б.Пунсалдулам. Цаасны хэмжээ В5.х.х. 9,3

Хэвлэсэн тоо 300 ш. Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК. УБ., 2019. “Чин сэтгэлийн үг” дурсамжийг Монгол Улсын Шинжлэх Ухааны гавьяат зүтгэлтэн, академич Ж.Болдбаатарын ажил, амьдралын намтар түүхийг судлан тодруулахад зориулсан болно. Тэрээр бүтээн байгуулалтын он жилүүдэд монголын боловсролын салбарт ажиллаж, сургалтын хөтөлбөр, агуулгын шинэчлэлд гар бие оролцон, өөрийн хүч оюуныг зориулжээ. Түүний ажил үйлс, бүтээлч хөдөлмөрийн талаар хамтран ажиллаж байсан 28 хүний дурсамж, тэмдэглэлийг оруулан эмхэтгэжээ.

2. **“Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа, дурсамж”** Эрхэлсэн Ц.Энхжаргал.

Цаасны хэмжээ В5.х.х.20. Хэвлэсэн тоо 300ш, Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК. УБ., 2022. Аман түүх, дурсамж нь түүхэн үйл явцыг баримт тоо, эх сурвалжаар батлахын хамт, түүхэн үйл явцад гар бие оролцож явсан хүмүүсийн хууч яриа, дурсамжаар давхар нотлон харуулах нэгэн чухал түүхийн судалгааны эх сурвалж юм. Иймд, (ШуСс-2019/62) суурь судалгааны төслийн хүрээнд “Бүтээн байгуулалт”-ын он жилүүдэд УААА-н олон салбарт чин хүсэл эрмэлзэл дүүрэн ажиллаж, зүтгэж явсан 28 ахмадуудын хууч яриа, дурсамжийг эмхэтгэн хэвлүүлэв.

Тухайлбал, О.Бадамсэд “Төмөр зам: ажил амьдралын их сургууль”, Д.Бадарч “Таван жилийн төлөвлөгөөт жилүүдэд газар тариалангийн зорилт хэрэгжсэн нь”, С.Гүндэнбал “Төлөвлөгөөт он жилүүдийн түүхэн цаг үед хөдөлмөрлөж явсан минь”, Ц.Дуламсүрэн “Нэгдлийн үеийг эргэн дурсахад”, Ч.Дандарваанчиг “Сумынхаа санхүү бүртгэлийн ажилд хагас зуун жил зүтгэсэн нь” зэрэг сонирхолтой хууч, яриа дурсамжийг оруулжээ.



**“БНМАУ-ЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОЛТ: ТУРШЛАГА,  
СУРГАМЖ (1954-1980-ААД ОНЫ СҮҮЛЧ)” ШУСс-2019/62 ГЭРЭЭТ ТӨСЛӨӨР  
ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

I. Эрдэм шинжилгээний хурал

**“БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж (1954-1980-аад оны сүүлч)** эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 9 дүгээр сарын 21-нд ШУА-ийн Нэгдсэн I байрны 410 тоот хурлын танхимд зохион байгуулав. Эрдэм шинжилгээний хуралд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Бүс нутаг, орчин үеийн түүхийн салбарын болон Нийгэм соёлын хүн судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судлаач эрдэмтэд, МУИС, МУБИС-ийн багш оюутнууд оролцож, нийт 20 илтгэл хэлэлцүүлээ.

Тус хуралд академич Ж.Болдбаатар “БНМАУ-ын тоталитаризмаас авторитари дэглэмд: үйл явц, үр дагавар”, академич Ц.Батбаяр “Бандунгийн бага хурал ба БНМАУ-ын гадаад харилцаа”, Sc.D, профессор Б.Пунсалдулам “БНМАУ-ын бүтээн байгуулалт: үйл явц, үр дүн, ард иргэдийн үүрэг оролцоо”, МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш доктор (Ph.D) Н.Алтантөгс “ХААН-н мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ (1960-1990 он)” мөн сургуулийн багш, доктор, дэд профессор Э.Жигмэддорж “БНМАУ-ын бүтээн байгуулалт хөдөө орон нутагт (Булган аймгийн хөдөө аж ахуйн салбарын жишээгээр), МУБИС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор Ч.Болдбаатар “БНМАУ-ын их хурлын депутат: Нэр дэвшүүлэх, сонгох журам, чиг үүрэг, бүрэлдэхүүн (1951-1960)” , мөн тус сургуулийн багш, доктор (Ph.D), дэд профессор С.Энхжин “Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарын удирдлагыг боловсронгуй болгох үйл явц (1954-1989), ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Нийгэм соёлын хүн судлалын салбарын ахмад ажилтан доктор (Ph.D), профессор Г.Цэрэнханд, докторант М.Энхбаатарын хамт “Нэгдэлч малчдын бэлчээрийн тухайд” зэрэг сонирхолтой, асуудал дэвшүүлсэн илтгэлүүдийг хэлэлцүүлэв.

II. Төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу эрдэм шинжилгээний 4 өгүүллийг мэргэжлийн холбогдох сэтгүүлд хэвлэн нийтлүүлэв. Өгүүллүүдийг тайланд хавсаргав. Үүнд:

- Ж.Болдбаатар “Монгол улсын ардын зураач Очирын Цэвэгжав (1915-1975) -//Түүхийн судлал. Tomus XLIX. Fasciculus 1-22. УБ., 2020. т. 266-273

- Ц.Батбаяр “НҮБ-д Монголын асуудлыг хэлэлцсэн нь (1941-1961): БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаарх ЗХУ, АНУ-ын байр суурийн хувьсал өөрчлөлт -// “Олон улс судлал” сэтгүүл: ШУА-ийн ОУСХ. 2021, №44(112), т. 31-45
  - Б.Пунсалдулам “XX зууны боловсролын хөгжлийн үе шат, үр дүн” -// “Боловсрол” сэтгүүл. УБ., 2021. №5. т. 4-12
  - Ц.Энхжаргал “УААА, соёлыг хөгжүүлэх гурван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх болсны учир шалтгаан” -// Түүхийн судлал. Tomus XLIX. Fasciculus 1-22. УБ., 2020. т. 308-321
- III. “БНМАУ-ын нийгэм эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч ) суурь судалгааны төслийн ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу нийт 9 илтгэлийг эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэв. Илтгэлүүдийг хавсаргав. Үүнд:
- Ж.Болдбаатар “БНМАУ тоталитаризмаас авторитари дэглэмд: үйл явц, үр дагавар”
  - Ц.Батбаяр “Бандунгийн бага хурал ба БНМАУ-ын гадаад харилцаа
  - Б.Пунсалдулам “БНМАУ-ын бүтээн байгуулалт: үйл явц, үр дүн, ард иргэдийн үүрэг оролцоо”
  - Г.Мягмарсамбуу “Монгол, Зөвлөлийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа: эхлэл, үр дүн
  - Н.Алтантөгс “Хөдөө аж ахуй нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ (1960-1990 он)
  - Д.Эрдэнэбат “БНМАУ-ын аж үйлдвэрийн түүх (1954-1980 оны сүүлч) салбар, бүтэц, үр дүн (Г.Баттүшигийн хамт)
  - Ч.Батдорж “БНМАУ-ын биеийн тамир, спортын байгууллага: бүтэц, зохион байгуулалт”
  - Ц.Энхжаргал “УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөнд хүний хөгжлийн асуудлыг тусгасан нь (1961-1989 он)
  - Г.Цэрэнсугар “Бүтээн байгуулалтын үед ДЭХЗ-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол-0001” төсөл

**“БНМАУ-ЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОЛТ: ТУРШЛАГА,  
СУРГАМЖ (1954-1980-ААД ОНЫ СҮҮЛЧ) № ШУ/СС 2019/62  
СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД**

Сурталчилгаа:

1. **“Соёлын довтолгоо”**. Зохиогч Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Цаасны хэмжээ А5, х.х.4,3. Хэвлэсэн тоо 250ш, Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК.

Засгийн Газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын 6.3.9 судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх хүрээнд “Соёлын довтолгоо” хялбаршуулсан товхимлыг нийтэд зориулан хэвлэн гаргав. Уг товхимолд “Соёлын довтолгоо” явуулах болсон учир шалтгаан, хэрэгжилт, үйл явц, үе шат, хүрсэн үр дүнг тоймлон гаргав.

2. “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 төслийн гол үр дүнд хэвлэгдсэн бүтээлүүдийг нийгэмд сурталчлах, таниулах ажлыг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 цагт Монгол Улсын Үндэсний Номын сангийн Үнэт номын музей зохион байгуулж, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал доктор (Ph.D), дэд профессор Ц.Цэрэндорж, төслийн удирдагч Sc.D, профессор Б.Пунсалдулам, академич Ц.Батбаяр, “Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа, дурсамж” бүтээлд оролцогч төмөр замын ахмад ажилтан О.Бадамсэд, Ойрх үеийн судалгааны салбарын эрхлэгч доктор (Ph.D) Д.Эрдэнэбат нар судалгааны ажлын хүрээнд хийгдсэн бүтээлүүдийн тухай танилцуулга хийв.

3. “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 төслийн гол үр дүнд хэвлэгдсэн бүтээлүүдийг нийгэмд сурталчлах, таниулах ажлын хүрээнд төслийн удирдагч Sc.D, профессор Б.Пунсалдулам МҮОНРТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Зочин”-ны цагаар нэвтрүүлэгт оролцож, суурь судалгааны төслийн зорилго, хүрсэн үр дүнгийн талаар ярилцав.

4. “Gogo”, “Mpress.mn” зэрэг сайтуудад “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт:

Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 төслийн гол үр дүнд хэвлэгдсэн бүтээлүүдийг тухай ярилцлагыг төслийн удирдагч Sc.D, профессор Б.Пунсалдулам, академич Ц.Батбаяр нар өгөв.

## ДҮГНЭЛТ

“БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны захиалгаар, санхүүжүүлэгч Шинжлэх Ухаан, Технологийн Сангийн захирал С.Намсрайжавтай байгуулсан гэрээ, протокол, төслийн үр дүнгийн даалгавар, төслөөр гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэв.

Суурь судалгааны төслийн багт ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрх үеийн түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд, МУИС, МУБИС-ийн түүхийн тэнхимийн судлаач, багш нар оролцов. Мөн “БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж (1954-1980-аад оны сүүлч) эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж судалгаа, сургалт явуулдаг нийт 5 байгууллагын судлаач эрдэмтэд, багш, докторантуудын 20 илтгэл хэлэлцүүлэв.

Суурь судалгааны төслийн хэрэгжилтийн явцыг Шинжлэх Ухаан, Технологийн сангаас шалгасан хяналт-шинжилгээний ажлын хэсэгт “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайлаангаа хэлэлцүүлж, 98 хувийн үнэлгээ дүгнэлтийг авсан болно.

“БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) № ШуСс-2019/62 суурь судалгааны төслийн хүрээн хэвлэгдэн гарсан хамтын бүтээл нь Монголын түүхийн шинжлэх ухааны хүрсэн судалгааны түвшинд, арга зүйн шинэ хандлагыг баримтлан, үнэлгээ дүгнэлт өгөв.

Суурь судалгааны төслийн хүрээнд, хамтын бүтээлээс гадна, түүхийн судалгааг цаашид гүнзгийрүүлэн судлах, мөн сургалтад хэрэглэх зорилгоор “Монгол улсын газар тариалан (1911-2020он)” баримтын эмхэтгэлийг хэвлүүллээ.

Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам заасны дагуу судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх хүрээнд “Соёлын довтолгоо” хялбаршуулсан товхимлыг нийтэд зориулан хэвлэн гаргав. Мөн суурь судалгааны төслийн хүрээнд хэвлэгдсэн бүтээлүүдийг олон нийтэд сурталчлав.

**Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн судалгааны  
ажлын үр дүнд хэвлэгдсэн бүтээлийн номзүй**

**I. Ном бүтээл**

**Нэг сэдэвт хамтын бүтээл**

1. “БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) / редактор Г.Чулуунбаатар, УБ., Удам соёл ХХК., 2022. 452 тал
2. Налайх нэгэн зууны түүхийн товчоон. УБ., Мөнхийн үсэг ХХК., 2022. 352 тал

**Баримтын эмхэтгэл**

1. Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Монгол улсын газар тариалан (1911-2020 он). УБ., Удам соёл ХХК., 2021. 348 тал

**Хурлын эмхэтгэл**

1. Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. “БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт, амжилт сургамж” (1954-1980-аад оны сүүлч). УБ., Удам соёл ХХК., 2020. 277 тал

**Аман түүхийн бүтээл**

1. Ц.Энхжаргал. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. / ред. Ж.Болдбаатар, УБ., Удам соёл ХХК., 2022. 240 тал
2. Б.Пунсалдулам. Чин сэтгэлийн үг. УБ., Удам соёл ХХК., 2019. 112 тал

**Сурталчилгааны бүтээл**

1. Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Соёлын довтолгоо. УБ., Удам соёл ХХК., 2020. 67 тал

**II. Эрдэм шинжилгээний өгүүлэл**

1. Ц.Батбаяр. Бандунгийн бага хурал ба БНМАУ Ази, Африкийн орнуудтай харилцах цонх нээсэн нь (1955-1961). // “Олон Улс судлал”, 2020, № 1 /110/. т. 103-118
2. Ц.Батбаяр. М.Горбачев, Дэн Сяопин нарын 1989 оны дээд хэмжээний уулзалт ба Монголын хувь заяаны асуудал. // “Олон улсын харилцаа”, МУИС, ОУХНУС-ийн сэтгүүл. 2020, № 1 /41 (556). т. 25-38
3. Ц.Батбаяр. НҮБ-д Монголын асуудлыг хэлэлцсэн нь (1946-1961 он): БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаарх ЗХУ, АНУ-ын байр суурийн хувьсал өөрчлөлт // “Олон улс судлал” сэтгүүл: ШУА-ийн ОУСХ, 2021, № 44 (112), т. 31-45

4. Ц.Батбаяр. XX зууны Монгол-Японы харилцааг “гуравдагч хөрш”-ийн түүхийн үүднээс шинжихүй нь // *Mongolian and Northeast Asian Studies*, Tokyo, Vol. 7/2022, pp. 107-114
5. Ц.Батбаяр. Mongolia’s Journey to join the United Nations in 1946-1961: “Cold War” Factors and ideological Conflicts of the Great Powers // “The Mongolian Journal of International Affairs”, Vol. 22, December 2021, pp. 28-41
6. Ц.Батбаяр. Монгольский вопрос в ООН в 1946-1961 гг.: Фактор советской дипломатии в реализации законного права МНР в ООН // “Вестник Бурятского научного центра СО РАН”, № 1 (45), 2022, с. 72-77
7. Ц.Батбаяр. “Монгол ба Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон нь: 50 жилийн өндөрлөгөөс нягтлан шинжихүй” // “Олон улс судлал” сэтгүүл, 2022, № 45 /114/
8. Ж.Болдбаатар. Монгол улсын ардын зураач Очирын Цэвэгжав (1915-1975). // Түүхийн судлал. Tomus XLIX. Fasciculus 1-22. УБ., 2020. т. 266-273
9. Б.Пунсалдулам. XX зууны боловсролын хөгжлийн үе шат, үр дүн. // “Боловсрол” сэтгүүл.УБ., 2021. №5. т. 4-12
10. Б.Пунсалдулам. БНМАУ-ын шинжлэх ухааны хүрээлэн (1930-1960) // Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. УБ., 2021. №2. т. 4-12
11. Б.Пунсалдулам. XX зууны бүтээн байгуулалтад ард иргэд идэвхтэй оролцсон нь. // Иргэний оролцоо. УБ., 2020. т. 180-220
12. Б.Пунсалдулам. Монгол Зөвлөлтийн харилцаа: Газар тариалангийн салбарт 1959-1990.// МУБИС-ийн нийгэм хүмүүнлэгийн ухааны судлал №12(12). УБ., 2020. т. 232-242
13. Б.Пунсалдулам. Атрын III аян онцлог үр дүн.// *Historia mongolarum* Tom 18. Дугаар 537 (39), УБ., 2019 т. 169-188
14. Ц.Энхжаргал. УААА, соёлыг хөгжүүлэх гурван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх болсны учир шалтгаан // Түүхийн судлал. Tomus XLIX. Fasciculus 1-22. УБ., 2020. т. 308-321
15. Д.Эрдэнэбат. Бүтээн байгуулалт ба Х.Чойбалсан. // Түүхийн судлал. Tomus XLIX. Fasciculus 1-22. УБ., 2020. т. 296-307
16. Д.Эрдэнэбат. Монгол улсын Аж үйлдвэрийн яамны сайд М.Лувсанчоймбол: амьдрал, үйл ажиллагаанаас // Нүүдэлчдийн өв судлал Tomus II, Fasc 1-27. УБ., 2019. т. 130-146

17. Д.Эрдэнэбат. Бүтээн байгуулалтын жилүүд дэх Аж үйлдвэрийн хөгжлийн асуудалд (1959-1989) // Монголын архив (эрдэм шинжилгээ, арга зүйн сэтгүүл). УБ., 2019. №1 /18/ т. 37-51
18. Д.Эрдэнэбат. Монгол Беларусын харилцаа. Бүтээн байгуулалтын жилүүдэд. // Нүүдэлчдийн өв судлал Tomus XXII, Fasciculus 1-22. УБ., 2021. т. 225-240
19. Д.Эрдэнэбат. БНМАУ-ын бүтээн байгуулалтын хөгжилд тээврийн салбарын гүйцэтгэсэн үүрэг (1954-1989) // Түүхийн судлал-2021-д хэвлэлд шилжүүлсэн.

### **III. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл**

1. Ц.Батбаяр. Монгол улс НҮБ элссэн нь: Зөвлөлтийн дипломат харилцааны хүчин зүйл. “Орос Монголын харилцаа 100 жил. ОУЭШХ. ОХУ-ын Владивосток. 2021.08.09
2. Ц.Батбаяр. “Л.И.Брежневийн 1966 онд БНМАУ-д хийсэн айлчлал: Түүний онцлог ба ач холбогдол” илтгэл. // “Орос, Монголын дипломат харилцааны 100 жил: Найрамдалт харилцаанаас иж бүрэн стратегийн түншлэлд” ОУЭШХ. ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэн, Москва, 2021.10.20-21
3. Ц.Батбаяр. “Монгольский вопрос в ООН в 1955–1961 гг.: Эволюция советских и американских подходов к членству МНР в ООН”. // “XX-XXI зууны ОХУ болон Монгол Улс: Үндэсний ардчилсан хувьсгал ба дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ой” ОУЭШХ. ОХУ-ын Улаан Үд хот, 2021.09.12
4. Б.Пунсалдулам “Бүтээн байгуулалт: Монгол-Зөвлөлтийн харилцаа (1954-1989). // “Монгол-Оросын харилцаа 100 жил” ОУЭШХ. Улаанбаатар. 2021.11.02
5. Б.Пунсалдулам. Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагаа: Атрын анхдугаар аян. // Международная научная конференция “Монголия XX века и русско-монгольские отношения: история и экономика”. 28. Мая 2021. Иркутск
6. Б.Пунсалдулам. Роль русского населения в развитии земледелия монголии в начале XX век. Монголоведение в современном мире. Опыт исследования, перспективы развития. // Материал международной научной конференции (Улымчиевские чтения: X) Улан-Уде зда. Бурятского университет. 2019. стр. 160-170



7. Б.Пунсалдулам. “БНМАУ-ын “социалист бүтээн байгуулалт”-ын соёлын бодлогын тухайд. // “1921 Ардын хувьсгал-100 жил түүх ба орчин үе” ОУЭШХ. 2021. 12. 02. т. 315-324
8. Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Культурная политика и его реализации в годах плановой экономики мнр (с 1947-конца 1980 гг.) // Мир центральной Азии V. ОУЭШХ. Улан-Удэ. 2022.07.02
9. Б.Пунсалдулам. “Социалист бүтээн байгуулалт ба соёлын бодлогын харилцан хамаарал, үр нөлөө”. // “Mongolian language and Culture in contact” ОУЭШХ. Прага хот. 2022. 10. 27-28
10. Б.Пунсалдулам. “ХХ зууны Монголын боловсрол шашны боловсролын эзлэх байр суурь” // “Aspects of Mongolian Buddhism-Animals, Plants and Bioethics” ОУЭШХ. Будапешт. 2022. 10. 20-21
11. Ц.Энхжаргал. Бүтээн байгуулалт: Говь компани // Монгол-Японы хамтарсан 15-р симпозиум хурал. УБ., 2022.09.04

#### **IV. Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл**

1. Н.Алтантөгс. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт хэрэглээ. (1960-1990 он) // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 63-75
2. Ц.Батбаяр. Бандунгийн бага хурал ба БНМАУ-ын гадаад харилцаа // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 108-123
2. Ц.Батбаяр. “Монгол ба Японы хооронд дипломат харилцаа тогтоосон түүх: Монголын өнцгөөс шинжихүй” илтгэл // Монгол-Японы найрамдал, хамтын ажиллагааны байгууллагуудын “Их хуралдай” ЭШХ.2022.08.23.
3. Ч.Батдорж. БНМАУ-ын биеийн тамир спортын байгууллага: бүтэц зохион байгуулалт // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 208-217
4. Ж.Болдбаатар. БНМАУ тоталитаризмаас авторитари дэглэмд: үйл явц, үр дагавар. // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 7-21
5. Г.Мягмарсамбуу. Монгол, зөвлөлтийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа: эхлэл, үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 132-148


6. Б.Пунсалдулам. БНМАУ-ын бүтээн байгуулалт: үйл явц, үр дүн, ард иргэдийн оролцоо // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 22-39
7. Б.Пунсалдулам. Шинэ соёлын голомт: Нийслэл Улаанбаатар // Улаанбаатар хотын орчин үеийн соёлын түүх. 382 жилийн ойд зориулан хийсэн ЭШБХ. Хангарьд ордон. УБ., 2021.10.17
8. Б.Пунсалдулам. ХХ зууны бүтээн байгуулалт: Монголын залуусын үүрэг оролцоо // Монголын залуучуудын 100 жилийн ойд зориулсан ЭШХ. Улаанбаатар. 28.10.2021
9. Б.Пунсалдулам. ХХ зууны бүтээн байгуулалт: Монгол Зөвлөлтийн харилцаа. (1954-1989). 2021. 11.05
10. Г.Цэрэнсугар. Бүтээн байгуулалтын үед ДЭХБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол-0001” төсөл: үйл явц үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 235-246
11. Ц.Энхжаргал. УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөнд хүний хөгжлийн асуудлыг тусгасан нь (1961-1989 он) // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 194-207
12. Ц.Энхжаргал. Соёлын довтолгоо ахуй амьдралд нөлөөлсөн нь оршуулгын зан үйлийн жишээгээр // Монголчуудын оршуулгын зан үйл, уламжлал, орчин үе, чиг хандлага хурал. 2022.09.02 (хэвлэлд)
13. Д.Эрдэнэбат. Бүтээн байгуулалтын жилүүд дэх Улаанбаатар. //“Хот байгуулалтын түүхэн үйл явц, өнгөрсөн, одоо, ирээдүй” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 116-124
14. Д.Эрдэнэбат, Г.Баттүшиг. БНМАУ-ын аж үйлдвэрийн түүх (1954-1980-аад оны сүүлч): Салбар, бүтэц, ололт-үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 40-49

#### **V. Дурсамж аман түүх**

1. Ц.Батбаяр. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. Ж.Гөлгөө т.88-94, Ж.Ломбо т.168-178, Д.Энхбат т.234-240 нарын дурсамж
2. Ч.Батдорж. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. А.Дамба т.120-124, Л.Дорж т.143-149, Д.Жанар т.156-163, Я.Жанцандорж т.164-167, П.Мандшир т.183-186, З.Намжин т.187-194 нарын дурсамж


3. Г.Мягмарсамбуу. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. Г.Буянхишиг т.73-87, Д.Доохүү т.133-142 нарын дурсамж
4. Б.Пунсалдулам. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. Ц.Батсайхан т. 56-59, Х.Оюунгэрэл т.195-209, Л.Пүрэвбаатар т.210-214 нарын дурсамж
5. Ц.Энхжаргал. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. хүний их эмч Р.Алтанцацрал т.9-13, Академич Ж.Болдбаатар т.60-72, төлөвлөгөөний комиссын дарга С.Гүндэнбал т.95-104, комбайнч Д.Магсаржав т.179-182 нарын дурсамж
6. Д.Эрдэнэбат. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. УБ., 2020. хөдөө аж ахуйн гавьяат ажилтан Д.Бадарч т.29-55, санхүү-банкны тэргүүний ажилтан Ч.Дандарваанчиг т.125-132, хөдөлмөрийн баатар С.Туяа т.218-220 нараас дурсамж авсан.

## Төслийн хүрээнд хэвлүүлсэн бүтээл




### Нэг сэдэвт хамтын бүтээл

“БНМАУ-ын Нийгэм, эдийн засгийн ололт: Туршлага, сургамж (1954-1980-аад оны сүүлч) / редактор Г.Чулуунбаатар, УБ., Удам соёл ХХК., 2022. 452 тал




### Баримтын эмхэтгэл

Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Монгол улсын газар тариалан (1911-2020 он). УБ., Удам соёл ХХК., 2021. 348 тал




### Хурлын эмхэтгэл

Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. “БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт, амжилт сургамж” (1954-1980-аад оны сүүлч). УБ., Удам соёл ХХК., 2020. 277 тал




### **Аман түүхийн бүтээл**

Ц.Энхжаргал. Бүтээн байгуулалтын жилүүд: хууч яриа дурсамж. / ред. Ж.Болдбаатар, УБ., Удам соёл ХХК., 2022. 240 тал



### **Аман түүхийн бүтээл**

Б.Пунсалдулам. Чин сэтгэлийн үг. УБ., Удам соёл ХХК., 2019. 112 тал



### **Сурталчилгааны бүтээл**

Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал. Соёлын довтолгоо. УБ., Удам соёл ХХК., 2020. 67 тал

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

1. Н.Алтантөгс. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт хэрэглээ. (1960-1990 он) // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 63-75
2. Ц.Батбаяр. Бандунгийн бага хурал ба БНМАУ-ын гадаад харилцаа // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 108-123
3. Ч.Батдорж. БНМАУ-ын биеийн тамир спортын байгууллага: бүтэц зохион байгуулалт // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 208-217
4. Ж.Болдбаатар. БНМАУ тоталитаризмаас авторитари дэглэмд: үйл явц, үр дагавар. // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 7-21
5. Г.Мягмарсамбуу. Монгол, зөвлөлтийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа: эхлэл, үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 132-148
6. Б.Пунсалдулам. БНМАУ-ын бүтээн байгуулалт: үйл явц, үр дүн, ард иргэдийн оролцоо // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 22-39
7. Г.Цэрэнсугар. Бүтээн байгуулалтын үед ДЭХБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол-0001” төсөл: үйл явц үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 235-246
8. Ц.Энхжаргал. УААА, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөнд хүний хөгжлийн асуудлыг тусгасан нь (1961-1989 он) // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 194-207
9. Д.Эрдэнэбат, Г.Баттүшиг. БНМАУ-ын аж үйлдвэрийн түүх (1954-1980-аад оны сүүлч): Салбар, бүтэц, ололт-үр дүн // БНМАУ-ын бүтээн байгуулалт: ололт амжилт сургамж. (1954-1980-аад оны сүүлч) ЭШХ. 2020.09.21. УБ., 2020. т. 40-49

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ